



БАЯНХОНГОР АЙМАГ  
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны ав сарын 15 өдөр

Дугаар 4/18

Хөхбурд

Г Сумын урд талын Ногоон байгууламжруу  
өндөр хүчдлийн шугам татах  
тендерийн үнэлгээний хороо  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.3, 46 дугаар зүйлийн 46.1.1 заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын урд талын Ногоон байгууламжруу өндөр хүчдлийн шугам татах тендерт оролцогчдыг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Д.Эрдэнэбулган (Санхүүгийн албаны дарга)

Гишүүд: Б.Үлэмжсонин (Эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч)

Г.Ууганжаргал (Татвар хураагч)

Ж.Ганцэцэг (Иргэний төлөөлөл)

Нарийн бичгийн дарга: Д.Отгонцэцэг (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

2. Тендерийн үнэлгээний хороонд ажиллах гишүүд нь Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т заасан мэдээллийг гаргаж, тендерт сонгон шалгаруулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа авах үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль тогтоомжийг чанд мөрдөн ажиллахыг үнэлгээний хорооны гишүүдэд даалгасугай.

3. Тендерийн материалыг баталгаажуулан стандартын дагуу архивын нэгж үүсгэн Засаг даргын Тамгын газрын архивт хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны Нарийн бичгийн дарга (Д.Отгонцэцэг)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.ХАТАНБААТАР

642201186